

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	3
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	7
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	10
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	11
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ....	12
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	14
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	16
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	18
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	19
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
ДҮГНЭЛТ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ.....	23

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. “Пепси” ундааны үйлдвэрийн байршлын тойм зураг .....5

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1.Төсөл хэрэгжих газрын хашааны захын цэгүүдийн солбицол ..... 6

Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ажлууд  
..... 12

Хүснэгт 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө ..... 14

Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө..... 15

Хүснэгт 5. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө ..... 16

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ..... 18

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр..... 19

Хүснэгт 8. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө ..... 20

Хүснэгт 9. БОМТ-ий хэрэгжилтийг тайлагнах хуваарь ..... 22

Хүснэгт 10. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал..... 23

### НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Жи Эн Бевережис” ХХК нь 2008 онд гадаад худалдаа, ундаа жүүсний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр байгуулагдсан. 2008 оны есдүгээр сард АНУ-ын ПэпсиКо Интернэшнлтэй хамтын ажиллагаагаа эхлүүлснээр дэлхийд алдартай брэндүүдийг эх орондоо үйлдвэрлэж, дотоодын үнээр хэрэглэгчиддээ хүргэж эхэлсэн.

Манай компани 2017 оны 8-р сард ОУ-ын FSSC 22000 стандартыг Монголд хэрэгжүүлэгчийн сертификат гардаж авсан дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол улсын хоёр дахь үндэсний үйлдвэрлэгч компани юм.



**Зураг 1. “Жи Эн Бевережис” ХХК-ийн оффисын барилга**

“Пепси” ундааны үйлдвэр нь Pepsi, Lipton Ice Tea, Mountain Dew, Sting, 7Up, Miranda гэсэн 14 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дөрвөн төрлийн савлагаатайгаар үйлдвэрлэж, Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн 300 гаруй сумын 10000 гаруй харилцагчдад худалдаалдаг. Цагт 18000 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай. Мөн POSTMIX машинд зориулсан 20 летрийн савалгаатай 4 төрлийн BIB сиропыг үйлдвэрлэдэг ба цагт 600 сав бүтээгдэхүүнийг савлах хүчин чадалтай.



**Зураг 2. “Пепси” ундааны үйлдвэрийн барилга**


“Пепси” ундааны үйлдвэрийн ундаа үйлдвэрлэх үндсэн түүхий эд нь бүтээгдэхүүн тус бүрийн найрлагад ордог хүнсний нэмэлт буюу концентрациуд, ус, элсэн чихэр, нүүрсхүчлийн хий байдаг. Харин туслах түүхий эд, материалуудад бүтээгдэхүүний савлагаанд ашигладаг бөглөө, хуруу шил, шошго, багцлагч рулон, ВВ уут, ВВ хайрцаг орох бөгөөд Тайланд, БНХАУ, Солонгос зэрэг улсуудаас импортлож байна.

“Пепси” ундааны үйлдвэрийн үйл ажиллагааны үед химийн лаборатори техник тоног төхөөрөмжийн угаалга, цэвэрлэгээ ариутгалын зориулалтаар 119 нэр төрлийн химийн бодис, хольцуудыг ашиглахаар төлөвлөж байна. Харин микробиологийн лабораторид 67 нэр төрлийн тэжээлт орчинг шинжилгээний зориулалтаар хэрэглэдэг ба цаашид ч ашиглахаар төлөвлөж байна.

2023 онд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тооцооноос үзэхэд жилд 21 сая орчим, хоногт 57534 ширхэг ундаа үйлдвэрлэсэн байна. Одоогоор 238 гаруй ажилтантай, маркетингийн газар, борлуулалтын газар, санхүүгийн газар, үйлдвэрийн газар, гадаад харилцаа төлөвлөлтийн алба, захиргаа хүний нөөцийн алба, инженер техникийн алба, түгээлт ачилтын албатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

“Пепси ундаа үйлдвэрлэх төсөл”-ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

“Пепси ундаа үйлдвэрлэх төсөл” нь Хан-Уул дүүргийн 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, 45 тоотод байрлана. Эзэмшил талбайн нийт хэмжээ нь 18250 м<sup>2</sup>. Төслийн талбайн байршлыг зураг болон хүснэгтээр доор харуулав.



Зураг 3. “Пепси” ундааны үйлдвэрийн байршлын тойм зураг

Хүснэгт 1.Төсөл хэрэгжих газрын хашааны захын цэгүүдийн солбицол

Цэгийн дугаар	Тэгш өнцөгт солбицол	
	Х	Ү
1	5309097.64	640720.50
2	5309078.50	640691.47
3	5309033.89	640618.67
4	5309010.54	640580.82
5	5309009.92	640580.75
6	5309007.36	640576.41
7	5308999.83	640564.92
8	5308986.05	640543.66
9	5308993.92	640534.94
10	5309015.04	640552.39
11	5309017.81	640554.67
12	5309025.27	640561.21
13	5309065.88	640596.61
14	5309142.04	640664.04
15	5309151.52	640674.72
16	5309173.20	640661.24
17	5309240.98	640739.04
18	5309141.38	640786.86

## ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчны төлөв байдал

**Агаар орчин:** “Пепси” ундааны үйлдвэрийн талбай нь Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт оршдог. Тус бүс нутаг нь үйлдвэрлэл хөгжсөн, мөн орон сууцны “Алтай”, “River stone” болон бусад хотхоны төвлөрсөн бүс юм. Төслийн талбай нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хороонд үйлдвэржилтийн бүсэд байрлаж байна. Ундааны үйлдвэр орчимд агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэхүйц томоохон эх үүсвэр одоогоор байхгүй байна. Харин “Пепси” ундааны үйлдвэр нь төвийн дулааны шугамд холбогдсон тул төслийн үйл ажиллагаанаас гадаад орчны агаарыг бохирдуулах хүчин зүйл байхгүй.

**Хөрсөн бүрхэвч:** Улаанбаатар хот орчим нь хөрс, газарзүйн мужлалаар Хангайн био уур амьсгалын их мужийн хагас чийглэг өндөршлийн бүсчлэл бүхий Хэнтийн захын тойрогт багтана. “Пепси” ундааны үйлдвэрийн төслийн талбайд тал газар, хөндий хотгорын хөрс тархсан байна. (МУ-ын Үндэсний Атлас, 2009)

Тус үйлдвэрийн хөрс нь шавранцар механик бүрэлдэхүүнтэй хар хүрэн хөрс тархсанаас хөрсний ерөнхий үржил шим дунд, хөрсөнд хийлгэсэн шинжилгээний дүнгээс үзвэл хүнд металл болон эрүүл ахуй, нянгийн бохирдолгүй, стандартаас давсан үзүүлэлт байхгүй, эрүүл хөрс байна. “Пепси” ундааны үйлдвэр нь 1.82 га талбайд үйл ажиллагаа явуулж байна. Тус үйлдвэр нь автомашины зогсоол, явган хүний зам болон үйлдвэрийн баруун талын задгай талбайг хатуу хучилттай болгосон. Мөн сул чөлөөтэй талбайд ногоон байгууламж байгуулж хөрс хамгаалах арга хэмжээг сайн авч ажилласан нь БОННУ-ний хээрийн судалгааны үед ажиглагдсан.

**Усан орчин:** Төсөл хэрэгжих талбай орчим нь Туул голын сав газарт хамрагдана. Туул голын тэжээлийн 25%-ийг ул хөрсний ус, 6%-ийг хайлсан цасны ус, 69%-ийг хур борооны ус эзлэх бөгөөд усны горимын хэв шинж нь хаврын шар усны болон зуны хур борооны үерийн горимоос хамаарна.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хамгийн том гадаргын усан сүлжээний илэрц нь Туул гол бөгөөд Туул гол руу цутгадаг жижиг голуудыг дурьдвал Өвөр горхи, Дэнд, Гачуурт, Улиастай, Хөл, Сэлбэ, Толгойт, Түргэн зэрэг голууд юм.

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Пепси” ундааны үйлдвэрийн хойд талаар 230 м зайд Дунд гол, 1 км зайд Туул гол

тус тус урсаж байна. Харин төсөл хэрэгжүүлэх талбайн хөрсний усны түвшин судалгаагаар 3.5 м-т байсан байна.

**Ургамлан нөмрөг:** “Пепси” ундааны үйлдвэр нь Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Монгол дагуурын уулын ойт хээрийн бүсээс хээрийн бүсэд шилжих шилжилтийн зааг бүс нутагт оршино. Улаанбаатар хот нь Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамрагддаг. “Пепси” ундааны үйлдвэрийн эзэмшил газар нь үйлдвэрийн барилга, хатуу хучилттай зам, талбай, авто машины зогсоолтой. Сул чөлөөтэй талбайд ногоон байгууламж байгуулж, улиас, хайлаас, гацуур, буйлс, сарнайн бут зэрэг гоёл чимэглэлийн мод, сөөг тарьж ургуулсан байна.

## 2.2. Нийгэм-эдийн засаг

Хан-Уул дүүрэг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын баруун урд хэсэгт дархан цаазат Богдхан уулын ар хормой, Туул голын хөвөөнд оршдог бөгөөд 48500 га нутаг дэвсгэртэй, үүнээс 21.1 хувь буюу 10226 га нь ой мод, гол горхи, рашаан ус бүхий дархлагдсан ногоон бүс, 67.6 хувь буюу 32763 га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 11.3 хувь буюу 5499 га нь хот суурин, зам харилцааны сүлжээ, нийтийн эзэмшлийн газарт хамаардаг.

Тус дүүрэг нь аж үйлдвэрийн томоохон бүс нутаг бөгөөд “Говь” ХК, “Гоёо” ХХК, “Кашмер Холдинг” ХХК, “МАК” корпораци, “АПУ” ХК, “Витафит” групп, “Таван богд” ХХК, “Атар өргөө” ХК, “Монфрэш” ХХК, “Жем интернейшнл” ХХК, Дулааны 3 дугаар цахилгаан станц” ТӨҮГ, МИАТ ХК, “Зорчигч Тээврийн нэгтгэл” ОНӨҮГ, “Биокомбинат” ОНӨҮГ зэрэг үндэсний томоохон компаниуд үйл ажиллагаа явуулж байна.

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр болох ХУД-ийн 3-р хороо нь 373 га газар нутаг, 4674 өрх, 16905 хүн амтай. Хойд талаараа Баянгол дүүргийн 3 дугаар хороо, зүүн болон урд талаараа Хан-Уул дүүргийн 2 дугаар хороотой, баруун талаараа Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороотой хиллэдэг.

Хороо нь дунд голоор зааглах Чингисийн өргөн чөлөө, Энгельс, Үйлдвэр, Ажилчны гудамжаар хиллэн байшин хороолол, үйлдвэрийн бүс болон Монгол Улсын томоохон аж үйлдвэрийн төвлөрсөн хороо юм. Тус хороонд нийт 250 гаруй аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулдаг ба үүнээс төрийн байгууллага нь Эрчим хүчний яам, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Дүүргийн Татварын хэлтэс, Дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, Дүүргийн Цагдаагийн хэлтэс, Дүүргийн Замын цагдаагийн тасаг зэрэг болно. Төрийн өмчит болон хувийн хэвшлийн байгууллагуудаас ТЭЦ-3, Автобус-1, Цахилгаан дамжуулах Сүлжээ



үндэсний сүлжээ, Говь, Гоёо, Витафит, Атар-Өргөө, Жем интернешнел, Бамбууш, Залуу Монгол, Мон-Фрейш, Эрэл групп, Таванбогд, Бармааш, Касс таун, MSM, Форвард моторс гэх мэт томоохон аж ахуй нэгжүүд үйл ажиллагаа явуулдаг.

## ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Пепси” ундааны үйлдвэрийн үйл ажиллагаанаас голлох сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлон үзүүлэв.

**Агаарын бохирдолт:** Тус үйлдвэр нь дулаан хангамжийн асуудлаа төвийн нэгдсэн дулааны шугам сүлжээнд холбогдож шийдвэрлэсэн бөгөөд төслийн талбайн зүгээс агаарын бохирдолд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

**Хөрс ба ургамалжилтад нөлөөлөх:** “Пепси” ундааны үйлдвэрийн төслийн талбайд үйлдвэрийн барилга байгууламж баригдаж зам талбайг хатуу хучилттай болгосон ба сул чөлөөтэй талбайд ногоон байгууламж байгуулсан байна. Цаашид төслийн зүгээс хөрс, ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

**Гадаргын болон гүний усанд нөлөөлөх:** Үйлдвэрийн талбайд гадаргын ил задгай гол, горхи, булаг шанд байхгүй юм. Тус төслийн хувьд үйлдвэрийн болон ахуйн хэрэглээний усаа төвийн шугам сүлжээнээс хангадаг ба үйлдвэрээс гарч буй шингэн хаягдлыг төвийн бохир усны нэгдсэн сүлжээнд нийлүүлдэг. Иймд гадаргын болон газрын гүний усанд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

**Амьтны аймагт нөлөөлөх:** Үйлдвэр байрлаж буй газар нь олон жилийн туршид хүний үйл ажиллагаанд өртсөн, эргэн тойрон нь барилгажсан, олон хөлийн газар тул тухайн орчинд төрөл бүрийн ан амьтан байхгүй. Өөрөөр хэлбэл үйлдвэрийн үйл ажиллагаанаас ан амьтанд учруулах сөрөг нөлөөлөлгүй байна.

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт нь энэхүү төслийг хэрэгжүүлэх үед технологийн онцлогоос хамааран газрын хөрс, түүний дээрх ургамал, газрын хурдас болон агаар мандалд тоос босох зэрэг сөргөөр нөлөөлөх тул дээрх сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэхийн тулд байгаль орчны мониторингийг тогтмол хийх, түүнийг нөхөн сэргээх ажлыг байгаль хамгаалах төлөвлөгөө, санхүүжилтэндээ тусган гүйцэтгэж ажиллана.

## ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Жи Эн Бевережис” ХХК нь “Пепси” ундааны үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаагийн хувьд БОННУ-ий тайланд тусгагдсан зөвлөмжийг баримтлах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах талаар явуулах үйл ажиллагаа нь дараах талбаруудад чиглэгдвэл зохино. Үүнд:

- Үйлдвэрийн ажлыг зохих технологийн дагуу, техникийн удирдагчийн удирдлагын дор явуулах ба техникийн удирдагчгүйгээр явуулахыг хориглоно.
- Үйлдвэрийн бүх ажлыг аюулгүй ажиллагааны дүрмийн заалтын дагуу хийх
- Үйлдвэрийн ургамалжуулсан талбай, түүний хүрээлэн буй орчин нь байгалийн тэнцвэрт байдлыг хадгалсан хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх
- Үйлдвэрийн орчинд галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал унтраах буланг тухай бүр шинэчлэх, шаардлагатай тохиолдолд нөхөн бүрдүүлэлт хийх
- Үйлдвэрийн талбайд ашиглалтын улмаас үүссэн болон ахуйн хог хаягдлыг цаг тухайд нь цэвэрлэх
- Галын аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгааг ажиллагсдад бүрэн өгч, гал түймрийн үед ажиллах зохион байгуулалт хийж мөрдөх
- Ногоон байгууламжийн арчилгаа, тордолтыг тогтмол хийх

**ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ажлууд**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
<b>Агаарын чанар</b>									
1.	Үйлдвэрийн орчимд сул шороон талбайгаас тоосжилт үүсэх	Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглах ууршилттай, шингэн төлөв бүхий химийн бодисуудын сав баглаа боодлын битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж байх	Агаарт химийн бодис алдагдахаас сэргийлэх	-	700.0	-	700.0	2024 онд	<ul style="list-style-type: none"> <li>✓ Агаарын тухай хууль</li> <li>✓ MNS 4585:2007 Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага</li> <li>✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль</li> <li>✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль</li> </ul>
2.		Агаарын бохирдлын төлбөрийг тогтмол төлөх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх	Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс хийн бохирдол ялгарахаас сэргийлэх				Үйл ажиллагааны зардалд тусгана.		<ul style="list-style-type: none"> <li>✓ “Бензин хөдөлгүүртэй автомашин–утааны найрлага дах хорт бодисын ЗДХ ба хэмжих арга” MNS 5013:2009</li> <li>✓ “Дизель хөдөлгүүртэй автомашин–утааны тортогжилтын ЗДХ ба хэмжих арга” MNS 5014:2009</li> </ul>
<b>Хөрс, ургамлан нөмрөг</b>									
3.	Хөрсний эвдрэл, бохирдол, доройтол	Ахуйн хатуу, шингэн хаягдлыг ил задгай асгаж хаяхгүй байх, үйлдвэрийн дотор орчинд ахуйн хаягдлыг 5 төрөлд ангилан ялгах сав байрлуулах, тэмдэг тэмдэглэгээг хийх	Хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах	-	500.0	-	500.0	Төсөл хэрэгжих бүх хугацаанд	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хог хаягдлын тухай хууль, 2017 он</li> <li>✓ Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344: 2011</li> </ul>

**“ПЕПСИ” УНДААНЫ ҮЙЛДВЭРИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

<b>4.</b>	Ургамлан нөмрөгийг арчлах, нөхөн сэргээх	Ундааны үйлдвэрийн хашаандахь ногоон байгууламжийг арчлах, тордох	Агаарын бохирдоос сэргийлэх	-	-	-	-	-	<ul style="list-style-type: none"> <li>✓ MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага</li> <li>✓ MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах</li> </ul>
<b>Нийт зардал</b>							<b>1200.0</b>		
<b>Гадаргын ба газрын доорх усны нөөц</b>									
<b>5.</b>	Газрын доорх усны нөөцөд сэргөөр нөлөөлөх	Бохир ус алдагдах, тунгаагуурын сан холболт алдах, шүүрэх, осол гэмтэл гарах, цахилгаан тасрах зэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх	Сангийн эвдрэл, гэмтлээс сэргийлэх	-	-	-	2000.0	Төсөл хэрэгжих бүх хугацаанд	<ul style="list-style-type: none"> <li>✓ Усны тухай хууль, 2012 он</li> <li>✓ Ундны усны чанарын стандарт MNS0900:2018</li> <li>✓ Гүний усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлагууд. MNS 3342:1982</li> </ul>
<b>6.</b>		Бохир ус цэвэршүүлэх байгууламж шинээр суурилуулж ашиглалтад оруулах	Газрын доорх усны бохирдлоос сэргийлэх	Үйл ажиллагааны зардалд тусгана.				2024 онд	<ul style="list-style-type: none"> <li>✓ MNS 6561:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус ерөнхий шаардлага</li> </ul>
<b>Нийт зардал</b>							<b>2000.0</b>		✓
<b>Бүх зардал</b>							<b>3200.0</b>		

**ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Дүйцүүлэн хамгаалын ажил хийх	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй хамтран Липтон төгөл байгуулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх		-	25000.0	-	25000.0	2024 онд	✓ MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт ✓ MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага ✓ MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах
2.	Эдэлбэр газрын ургамлан нөмрөгийг арчлах, нөхөн сэргээх	Ногоон байгууламжийг арчлах, хамгаалах, жил бүрийн намар цэнэг усалгаа хийх	Орчны тохижилтыг сайжруулах	-	-	-	-	2024 онд	
<b>Нийт зардал</b>							<b>25000.0</b>		

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Төслийн талбайд түүх соёлын өв, дурсгалт газар, олдвор байхгүй				Байхгүй			Соёлын өвийг хамгаалах тухай хууль Газрын тухай хууль
<b>Нийт зардал</b>						-		

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	ХАБЭА-н дүрэм журам зөрчигдөж осол гарахаас сэргийлэх	Ажиллагсдыг ХАБЭА-н хувцас хэрэгсэл буюу бээлий, малгай, чихний бөглөөс болон бусад хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж хэрэглэж хэвшүүлэх	Аливаа осол, эрсдэлээс сэргийлнэ.	-	80000.0	80000.0	2024 онд	✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он ✓ MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
2.		Ажилчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг, шинжилгээнд хамруулах		-	8000.0	8000.0	2024 онд	
3.		Анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг хяналтын өрөө эсвэл ажлын байранд ил харагдахаар газарт байрлуулах, тогтмол шинэчлэх		-	1000.0	1000.0	2024 онд	
4.	Химийн бодисын эрсдлээс урьдчилан сэргийлэх	Химийн бодисын үлдэгдэл, сав баглаа боодлын хаягдлыг зохих журмын дагуу зайлуулах	Аюултай хог хаягдал	-	-	-	2024 онд	✓ Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2006 он ✓ Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 ду
5.		Химийн бодистой ажиллаж буй бүх ажилчдад тухайн бодисын хор аюулын лавлах мэдээллийг танилцуулж, аюулгүй ажиллагааы зааварчилгааг тогтмол өгч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Үйлдвэрийн ажилчдад	-	-	-	2024 онд	



**“ПЕПСИ” УНДААНЫ ҮЙЛДВЭРИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

								гаар хамтарсан тушаалын хавсралт Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тэвэрлэх, ашиглах, устгах журам
6.	Галын аюулгүй байдлыг хангаагүйгээс гал түймрийн осол аварга өртөх	Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай галын хор, багаж хэрэгслүүдийг бүх объектуудад байрлуулах, хэвийн ажиллагааг шалгаж тэмдэглэх, шинэчлэх	Галын сарай, галын хор, багаж хэрэгсэл	-	5000.0	5000.0	2024 онд	<ul style="list-style-type: none"> <li>✓ Галын аюулгүй байдлын тухай хууль, 1999 он</li> <li>✓ MNS 5566 : 2020 Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм</li> </ul>
<b>Нийт зардал</b>						<b>94000.0</b>		

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Ахуйн хатуу хог хаягдлаар орчныг бохирдуулах	Ахуйн хаягдлыг төслийн эзэмшлийн ил задгай хаяхгүй байх, гэрээт байгууллагаар тээвэрлүүлэн зайлуулах	Ахуйн хог хаягдлаар үйлдвэрийн орчин бохирдохоос сэргийлнэ.	-	-	-	-	Сард 1 удаа	Хог хаягдлын тухай хууль, 2017 он Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344: 2011 Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам, ЗГ-ын 2018 оны 116-р тогтоол Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хураах, тээвэрлэх гэрээ
		Ахуйн хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис цацаж тогтмол ариутгаж байх		-	1000.0	-	1000.0	Сард 1 удаа	
		Дахин боловсруулах боломжгүй хаягдлыг тохижилт үйлчилгээний газраар гэрээний дагуу зайлуулах		-	-	-	-	Сард 1 удаа	
2	Ахуйн хатуу хог хаягдлаар орчныг бохирдуулах	Ангилж ялгасан дахин боловсруулах боломжтой ахуйн хатуу хог хаягдлыг дахиварын үйлдвэрт төвлөрүүлэх	Ундааны хуванцар савны хаягдлаа эргүүлэн татах	-	-	-	-	Сард 1 удаа	Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт, БОАЖСайд, Сангийн сайдын 2018 оны А/429/257 тушаал, Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам, БОАЖСайдын 2018 оны А/428 дугаар тушаал
Үйлдвэрлэгч нь хариуцах журмын дагуу худалдаанд гарсан ундааны хуванцар савны хаягдлаа эргүүлэн татах ажлыг 9-р сараас эхлүүлэн УБ хот дахь хотхон, СӨХ-үүдэд хуванцар цуглуулах савнууд байршуулна.		-		-	-	60915.0	09 дүгээр сараас		
3									
<b>Нийт зардал:</b>							61915.0		

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Байгаль орчны бүрдлүүд	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах эрхзүйн баримт бичиг
		1	2	3	4	5	6	7	8
1.	Агаар, хөрс, үйлдвэрийн хаягдал усны бохирдлоос урьдчилан сэргийлэх	Хорт хий, ББ-ууд: Тоос /PM10, PM2.5/ CO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , NO <sub>2</sub>	Үйлдвэрийн орчинд	Жилд 2 удаа	1 цэгт	80.0	160.0	2024 онд	<ul style="list-style-type: none"> <li>✓ Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5885: 2008/</li> <li>✓ Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016</li> </ul>
2.		Хөрсний үржил шим тодорхойлох	Үйлдвэрийн орчны хөрснөөс	Жилд 2 удаа	1 дээж	60.0	120.0	2024 онд	<ul style="list-style-type: none"> <li>✓ MNS 3310:1991 Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох арга</li> </ul>
3.		Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ	Үйлдвэрийн орчны хөрснөөс	Жилд 2 удаа	1 дээж	60.0	120.0	2024 онд	<ul style="list-style-type: none"> <li>✓ MNS ISO10390 Хөрсний чанар. pH тодорхойлох</li> <li>✓ MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх</li> </ul>
4.		Хөрсөн дэх хүнд металлын агууламж тодорхойлох	Үйлдвэрийн орчны хөрснөөс	Жилд 2 удаа	1 дээж	60.0	120.0	2024 онд	<ul style="list-style-type: none"> <li>✓ MNS 5850:2019. Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ</li> <li>✓ MNS ISO11466:2007 Хөрсний чанар - Хааны дарсанд уусдаг дагалдах элементүүдийг ялган уусгах</li> </ul>
5.		Хаягдал усны бохирдлын шинжилгээ	Үйлдвэрийн хаягдал уснаас	улирал бүр	1 дээж	70.0	280.0	2024 онд	<ul style="list-style-type: none"> <li>✓ 6561:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага</li> </ul>
<b>Нийт</b>						<b>330.0</b>	<b>800.0</b>		

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь 2024 он			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			Сар				
			3	4	5		
1	2	3	4	5	6	7	
1.	Ажилчдад ХАБЭА, химийн бодистой харьцах заавар, үйлдвэрлэлийн ослын үед анхан шатны тусламж үзүүлэх гэх мэт сэдвүүдийн хүрээнд ажилчдад зориулсан төлөвлөгөөт сургалт, сурталчилгааг тогтмол явуулж хэвшүүлэх	800.0	6, 7, 8 сард			Гүйцэтгэх захирал	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он</li> <li>✓ Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод журам</li> </ul>
2.	ТЖБОМТ-г өмнөх оны 12-р сард багтаан БОАЖЯ-аар батлуулж, уг ТЖБОМТ-нд тусгасан төлөвлөгөөт ажлуудаа тухайн ондоо хийж гүйцэтгэсэний дараа биелэлтийн тайланг боловсруулан 11-р сард багтаан орон нутгаас томилогдсон ажлын хэсгээр холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд нь дүгнүүлэх	-	11-12 сард			БО хариуцсан ажилтан	<ul style="list-style-type: none"> <li>✓ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам</li> </ul>
3.	Байгаль орчны аудитыг 2 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	7000.0	2024 онд			БО хариуцсан ажилтан Гүйцэтгэх захирал	<ul style="list-style-type: none"> <li>✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль</li> </ul>
4.	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	4000.0	2024 онд			БО хариуцсан ажилтан Гүйцэтгэх захирал	<ul style="list-style-type: none"> <li>✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль</li> <li>✓ Газрын тухай хууль</li> </ul>
5.	Төслийн үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл, гэрээ, дүгнэлтүүд (ус ашиглах гэрээ, ус ашиглах зөвшөөрөл, ажлын байрны дүгнэлт, галын аюулгүй байдлын дүгнэлт, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны гэрчилгээ)-	Гэрээний үнийн дүнгээр	1			Гүйцэтгэх захирал	<ul style="list-style-type: none"> <li>✓ Усны тухай хууль, 2012 он</li> <li>✓ Галын аюулгүй байдлын тухай хууль, 1999 он</li> <li>✓ Хог хаягдлын тухай хууль, 2017 он</li> </ul>

“ПЕПСИ” УНДААНЫ ҮЙЛДВЭРИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ийг гаргуулах, холбогдох төлбөр тооцоог тогтсон хугацаанд төлж байх						
<b>Нийт зардал</b>	<b>11800.0</b>					

**АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД  
ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Жи Эн Бевережис” ХХК нь “Пепси” ундааны үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хагас жил тутамд хүргүүлэх ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж оролцоно.

**Хүснэгт 9. БОМТ-ий хэрэгжилтийг тайлагнах хуваарь**

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Иргэд олон нийт/дурын оролцогч, сонирхогч талууд	Санал, хүсэлт хүлээн авч төсөлтэй холбогдох гомдлыг барагдуулах	Байгаль орчны талаар тавьсан санал гомдолтой холбогдол бүхий бүх төрлийн мэдээлэл	Төсөл хэрэгжих бүх хугацааны турш	50.0	Сонирхогч оролцогч талуудыг хүссэн мэдээллээр хангах	ХУД-ийн 3-р хорооны ИНХ-ын танхимд
2.	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, БОАЖЯ	ТЖБОМТ-г батлуулж, биелэлтийн тайлангаа дүгнүүлэх	Төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлуудын мэдээлэл	Жил бүрийн 11, 12-р саруудад	50.0	БОМТ түүний хэрэгжилт	-
3.	ХУД-ийн ЗДТГ	Жилийн тайланг хүргүүлж танилцуулга хийх ба санал авах		Жилийн эцсээр 1 удаа	50.0		-
4.	3-р хорооны ИНХ	Жилийн тайланг хүргүүлж танилцуулга хийх ба санал авах		Жилийн эцсээр 1 удаа	50.0		ХУД-ийн 3-р хорооны ИНХ-ын танхимд
5.	Нийслэлийн Байгаль орчны газар	Жилийн тайланг хүргүүлж дүгнүүлэх		11 сарын 01-ний дотор	-		НБОГ
<b>Нийт</b>					<b>200.0</b>		

**ДҮГНЭЛТ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ  
ЗАРДАЛ**

**Хүснэгт 10. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал**

<b>№</b>	<b>Зардлын ангилал</b>	<b>Зардал, мян.төг</b>
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	3200.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	25000.0
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	94000.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	61915.0
6	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	800.0
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	11800.0
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	200.0
<b>Нийт төсөв, мян.төг</b>		<b>196915.0</b>

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **196915.0 мянган төгрөг** зарцуулах урьдчилсан тооцоо гарлаа.